



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/181

Номгон

“Шүлхий” өвчнөөс урьдчилан сэргийлэх
2026 оны хаврын төлөвлөгөөт
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2018 оны “Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт батлах тухай” 225 дугаар тогтоолын 2 дахь заалт, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Шүлхий” өвчнөөс урьдчилан сэргийлэх 2026 оны хаврын төлөвлөгөөт дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай А/59 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, мэдрэмтгий мал, амьтны дархлаажуулах төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 28 хоногийн хугацаанд батлагдсан хуваарийн дагуу, технологит хугацаанд нь шуурхай зохион байгуулж, мэргэжил арга зүй, заавар, зөвлөмжөөр хангаж, дархлаажуулалт хамрагдаж буй нутагт дэвсгэрт “Вакцины дархлаа” тогтох хүртлэх хугацаанд малчдын нүүдэл, Мал мах борлуулах, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Оюун-Эрдэнэ), Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа (Т.Цэвээндорж), сум, багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр)-т даалгасугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ

626010451

Аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар
сарын 25-ны өдрийн 448/2 дугаар
захирамжийн 02 дүгээр хавсралт



ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ 2026 ОНЫ ХАВРЫН ТӨЛӨВЛӨГӨӨТ ДАРХЛААЖУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Нэг.Үндэслэл, зорилго

Дараах хүчин зүйлүүд нь энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл, зорилго болсон. **Үүнд:**

1.1. Шүлхий өвчний халдвар тархах эрсдэлийг зогсооход энэхүү ажлын үндэслэл, зорилго болно..

1.2. Үхэр нь шүлхий өвчинд хамгийн мэдрэмтгий, өвчний шинж тэмдэг нь хурц, тод илэрдэг зэргийг харгалзан сүргийн дотор уг өвчний халдвар тархах эрсдэл, улсын хэмжээнд шүлхий өвчний тархалтыг бууруулах, зогсооход чиглэсэн нь энэхүү ажлын үндэслэл болно.

Хоёр. Хэрэгжүүлэх хугацаа:

2.1. Дархлаажуулалтын арга хэмжээг 20 сумын 105 багийг хамруулан 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 28 хоногийн хугацаанд шуурхай хэрэгжүүлэх.

2.2. Дархлаажуулалтад үхэр, гахайг хамруулна.

Гурав. Хэрэгжүүлэх байгууллага:

3.1. Мал эмнэлгийн газар:

3.1.1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг харьяалах нутаг дэвсгэртээ шуурхай зохион байгуулж, батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу хамрагдвал зохих өрхийн мэдрэмтгий малыг бүрэн хамруулах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэн гүйцэтгэлийг хангуулан ажиллана.

3.1.2. МЭНС-ийн төлөвлөлтийг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний дотор бүрэн оруулж, төлөвлөлтийн бодит эсэхэд хяналт тавин ажиллана.

3.1.3. Сумдын мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид дархлаажуулалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, хуваарь, зохион байгуулах удирдамж, вакцины заавар, зөвлөмжийг танилцуулан мэргэжил арга зүй, заавар, зөвлөмжөөр хангана.

3.1.4. Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны

3.1.5.Вакцины саванд мал эмнэлгийн үйлчилгээний нэгж тус бүрээр ялгагдах тэмдэг, тэмдэглэгээ хийж, нэгжүүдэд олгох ажлыг зохион байгуулна.

3.2.Сүмдын мал эмнэлгийн тасаг:

3.2.1.Сүмдын Мал эмнэлгийн тасаг нь харьяалах нутаг дэвсгэртээ орон нутгийн удирдлагуудтай хамран ажиллаж, шаардагдах хүн хүчний нөөц, техник хэрэгслийн нөөц бололцоог ашиглаж дархлаажуулалтын ажлыг үр дүнтэй, товлосон хугацаанд зохион байгуулан явцын хяналт тавих, өдөр тутмын үр дүнг нэгтгэх, тайлагнах ажлыг хариуцна.

3.2.2.Дархлаажуулалт эхлэхээс өмнө батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу мал эмнэлгийн нэгдсэн системд хамрагдвал зохих малчин өрх болон малын төлөвлөлтийг статистикийн мэдээллийг үндэслэн оруулж бэлтгэл ажлыг хангуулна.

3.2.3.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт заасны дагуу дархлаажуулалтын товыг багийн Засаг даргад хүргэн малчин, амьтан маллагчид зарлан мэдээлэх, дархлаажуулалтад мал сүргээ хамруулах тухай хуулиар тогтоосон малчны үүргийг танилцуулах ажлыг хамтран зохион байгуулна.

3.2.4.Зайлшгүй шаардлагаар хэрэгжүүлэх мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ хамруулах тухай хуулиар тогтоосон малчны үүргийг мал эмнэлгийн тасаг, нэгж малчин бүрд танилцуулан албажуулна.

3.2.5.Вакцины савны тэмдэг, тэмдэглэгээг шалган нэгжүүдээс хүлээн авч, үлдэгдэл, хорогдлын шалтгаан нөхцөлийг тогтоож, зааврын дагуу халдваргүйжүүлэх, устгах арга хэмжээг зохион байгуулан хяналт тавин ажиллана.

3.3.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж:

3.3.1.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу дархлаажуулалтад хамрагдвал зохих малчин өрх болон малыг товлосон хугацаанд бүрэн хамруулан тарилгыг хууль, тогтоомж, зааврын дагуу гүйцэтгэн үр дүнг тайлагнан ажиллана.

3.3.2.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар харьяалах нутаг дэвсгэрийн малчин, амьтан маллагч, мал, амьган өмчлөгчид зөвлөгөө өгч, зайлшгүй шаардлагаар хэрэгжүүлэх мал эмнэлгийн арга хэмжээнд мал сүргээ хамруулах тухай хуулиар тогтоосон малчны үүргийг сурталчлан таниулна.

3.3.3.Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь тарилга хийхээс өмнө болон тарилгын явцад шинж тэмдгийн үзлэг ажиглалт хийх, өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийх, мэдээллийг малчны хотноос мал эмнэлгийн нэгдсэн цахим системд оруулах, арга хэмжээг хэрэгжүүлнэ. (САЗ)

Дөрөв.Шүлхийн дархлаажуулалтыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал:

4.1.1.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх идэвхгүйжүүлсэн вакциныг хэрэглэх заавар, МЭЭГ-ын даргын баталсан стандарт ажиллагааны зааварчилгаа (САЗ)-г баримталж тарилгын арга хэмжээг гүйцэтгэнэ.

4.1.2.МЭГ-аас баталсан хуваарьт өөрчлөлт оруулсан тохиолдолд шинэчилсэн

хуваарь болон холбогдох тайлбарыг МЭГ-т албан бичгээр ирүүлнэ.

4.1.3.Дархлаажуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ цаг агаарын байдалтай холбогдуулан багийн гишүүдийн аюулгүй байдлыг сайтар хангасан байхаар арга хэмжээг зохион байгуулна.

4.1.4.Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээ хэрэгжүүлэх зураглалыг сум болон багийн түвшинд гаргаж, зураглалын дагуу тарилгын ажлыг гүйцэтгэнэ. (САЗ)

4.1.5.Тухайн вакцины хэрэглэх заавар болон хадгалах, тээвэрлэх нөхцөлийн талаар мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт тусгайлан танилцуулж, гарын үсэг зуруулж, баталгаажуулна.

4.1.6.Дархлаажуулалтын арга хэмжээг хамрагдах өрх бүрийн гадна хашаа, саравчинд тарихаар, нэг цэгт 1-ээс дээш хот айлын малыг цуглуулж тарихгүй байхаар зохион байгуулна.

4.1.7.Дархлаажуулалт хийгдэж буй тухайн суманд байгаа өөр аймаг, сумаас оторлож яваа малыг үлдээхгүй тарилгад хамруулна. Отор нүүдлээр яваа малчдад нутаг сэлгэхдээ анхаарах асуудлаар зөвлөмж өгнө.

4.1.8.Вакцины зааврыг мөрдөхөөс гадна цодонг задалснаас хойших хэрэглэж дуусах хугацааг чанд баримтлан ажиллана.

4.1.9.Дархлаажуулалтын арга хэмжээнд автомат тариур хэрэглэхээс зайлсхийж аль болох нэг удаагийн тариур ашиглана. Автомат тариур ашигласан тохиолдолд хий сорогдох, дутуу болон гадуур нь шахагдах зэрэг алдаа гарахаас сэргийлж ажиллана.

4.1.10.Малыг дархлаажуулахын өмнө тодорхой тооны малд тарилга хийж алдаа гарч байгаа эсэхийг шалгана.

4.1.11.Нэг өрхөд ашигласан тариурын зүүг дараагийн өрхөд ашиглахгүй байх, өрх бүрийн малыг дархлаажуулахын өмнө тодорхой тооны малд тарилга хийж алдаа гарч байгаа эсэхийг шалгана.

4.1.12.Вакциныг малчинд үлдээх болон мал, амьтан эмчлэх итгэмжлэлгүй, эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулаагүй мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэгч тарилга хийхийг хориглоно.

4.1.13.Дархлаажуулсны дараа дахин өвчлөл бүртгэгдсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.1.14.Дархлаажуулалтын арга хэмжээний талаар зохих мэдээлэл, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зөвлөмжийг малчдад өгнө.

4.1.15.Вакциныг хэрэглэх зааварт заасан бүрэн дархлаа тогтох хугацаа /28 хоног/ хүртэл тарилгад хамрагдсан өрх нь отор нүүдэл, шилжилт хөдөлгөөн хийхгүй байх анхааруулгыг малчдад өгнө. (САЗ).

Тав. Дархлаажуулалтын гүйцэтгэлийн болон технологийн хяналт

5.1.Дархлаажуулалтыг мал эмнэлгийн байгууллага болон мал эмнэлгийн тасаг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллана.

5.2. Мал эмнэлгийн газрын мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч сум бүрийн хамрагдвал зохих өрхийн төлөвлөлт МЭНС-д бүрэн орсон эсэхийг статистик мэдээллийн тоотой тулган хэрэгжилтийн явцыг хянаж баталгаажуулна.

5.3. МЭГ-аас дархлаажуулалтын хяналтын баг томилж, нэгж, малчин өрхийг санамсаргүй сонголтын аргаар сонгож гүйцэтгэлийн хяналт хийнэ.

5.4. Сумын тасгийн мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч вакцин хүлээн авсан, дархлаажуулалт эхэлсэн, дууссан хугацаа болон ажилласан мал таригч, мал баригчийн мэдээллийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгж тус бүрээр нарийвчлан тогтоох замаар тарилгын гүйцэтгэлийн тойм судалгаа хийнэ.

5.5. Дархлаажуулалтын гүйцэтгэлийн хяналт хийхдээ малын тооны статистик мэдээлэл болон төлөвлөлт, гүйцэтгэлийг тулган нягталж, хэвийн хорогдлын хэмжээ, зөрүү гарсан шалтгаан нөхцөлийн тодруулан мал эмнэлгийн нэгдсэн системд баталгаажуулна.

5.6. Хяналтын баг болон тасгийн мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч товлосон хугацаанд дархлаажуулалт эхэлж буй эсэх, төлөвлөгөөт мал бүрэн хамрагдаж буй эсэх, вакцины хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн горим зөрчигдөж байгаа эсэх, тарилгын явцад технологийн алдаа гарч байгаа эсэх, орхигдсон айл өрх, мал байгаа эсэх, мал эмнэлгийн нэгдсэн системд тухайн тарилга хийж байгаа цэгээс гүйцэтгэл оруулж байгаа эсэхийг хянана.

5.7. Дархлаажуулалтын технологийн хяналтыг тухайн сум, багаас эрсдэл бүхий гэж үзсэн өрх, нэгжийг сонгон тарилга хийж буй нэгжүүдээс сонгон тарилга явагдаж буй тухайн газар дээр нь очиж хянан хэрэгжүүлнэ.

5.8. Сумын тасгийн мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч харьяалах сумын төлөвлөгөөт дархлаажуулалтын төлөвлөлт, гүйцэтгэлийг хянан МЭНС-д баталгаажуулж, хяналтын дүнг үндэслэн улсын байцаагчийн дүгнэлт гаргана.

5.9. Мал эмнэлгийн газрын мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч тухайн харьяалах аймгийн хэмжээнд хийгдсэн төлөвлөгөөт дархлаажуулалтын төлөвлөлт, гүйцэтгэлийг хянан МЭНС-д баталгаажуулж, хяналтын дүнг үндэслэн улсын байцаагчийн нэгдсэн дүгнэлт гаргана.

5.10. Төлөвлөгөөт дархлаажуулалтад мал сүргээ хамруулаагүй тохиолдолд мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч холбогдох хууль тогтоомжийн хариуцлага тооцож, хохирол, нөхөн төлбөрийг тогтоон ажиллана.

5.11. Хяналт хийсэн дүнг батлагдсан маяг, загварын дагуу гарган улсын байцаагчийн дүгнэлтийн хамт тарилгын баримт бичгийн бүрдүүлэлтэд хавсарган ирүүлнэ.

Зургаа. Тайлагнах

6.1. Дархлаажуулалтын ажлыг малын тооны статистик мэдээлэл болон дархлаажуулалтад хамрагдсан малын мэдээллийг тулган нягтлах, зөрүү гарсан тохиолдолд шалтгааныг тодруулж цахим системийн үр дүн оруулах хэсгийн тайлбар хэсэгт тэмдэглэнэ.

6.2. Удирдамжийн дагуу сумын МЭТ илтгэх хуудас бичиж МЭГ-т хүргүүлэх, МЭГ газар сумдын илтгэх хуудсыг нэгтгэн МЭЕГ-т тарилгын материалын хамт хүргүүлнэ.

6.3.Дархлаажуулалтын гүйцэтгэлийн болон технологийн хяналтын дүнг нэгдсэн арга хэмжээ эхэлснээс хойших 7, 14, 28 дахь хоногуудаар, тарилгын гүйцэтгэлийн тойм судалгааг 2025 оны 11 дүгээр сарын 15-наар тасалбар болгон холбогдох загварын дагуу сумдын дүнгээр нэгтгэн Adiyasuren@bkh.vet.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.

6.4.МЭҮН-ийн эмч нь тарилгын материалыг 2026 оны 4 дүгээр сарын 20-ны дотор МЭТ-т, МЭТ-аас 04 дүгээр сарын 25-ны дотор аймгийн МЭГ-т хүргүүлсэн байна.

6.5.Тарилгын материалыг дор дурдсан дараалалд оруулан эх хувь үйлдэж ирүүлнэ.

6.6.Санхүүжилт хүссэн албан бичиг

6.7.Сумдын засаг даргын захирамж хавсралтын хамт

6.8.Мал эмнэлгийн байцаагчийн дүгнэлт (зарцуулсан вакцин, үлдэгдэл тун, хэвийн хорогдлыг тунгаар тооцож тусгах хэрэв мал эмнэлгийн газрын тушаалаар батлагдсан хуваарьт өөрчлөлт орсон бол холбогдох тайлбарыг тусгах)

6.9.Тарилга хийсэн акт (зарцуулсан вакцин, үлдэгдэл тун, хэвийн хорогдлыг тунгаар тооцож тусгах, хэрэв мал эмнэлгийн ерөнхий газрын тушаалаар батлагдсан хуваарьт өөрчлөлт орсон бол холбогдох тайлбарыг тусгах)

6.10.Тухайн сумдын МЭТ-н дархлаажуулалтын ажлын тайлан

6.11.Төлөвлөгөөт дархлаажуулалтын дүн, үйлчилгээний хөлс, вакцины тооцоог батлуулан ирүүлэх. (Илгээсэн загвар хүснэгт ашиглах)

Долоо. Хариуцлага

7.1. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нар дархлаажуулалтад хамрагдаж буй малчин өрхийн үхэр сүргийг бүрэн хамруулаагүйгээс шалтгаалан өвчлөл гарсан тохиолдолд

7.2.Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч дархлаажуулалтын явцын хяналт тавиагүй дүгнэлт гаргасан тохиолдолд хуулийн дагуу хариуцлага тооцно.

-----oOo-----

Аймгийн Засаг даргын 03-ны 03 дугаар
сарын 16-ны өдрийн 4/1 дүгээр
захирамжийн 03 дугаар хавсралт

ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХАВРЫН ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХУВААРЬ

Д/д	Сумын нэр	Өрхийн тоо	Намрын дархлаажуулалт							
			Үхэр	Тугал	Гахай	Нийт	Шаардагдах вакцин	Нийт олгох вакцин		
							Тун	Тун	Хайрцаг	Шил
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Баянхонгор	251	15000		30	15,030	15100			
2	Баацагаан	181	8500			8,500	8500			
3	Баянбулаг	273	6350			6,350	6300			
4	Баянговь	52	1575			1,575	1500			
5	Баянлиг	121	1631			1,631	1600			
6	Баян-Овоо	204	9188			9,188	9200			
7	Баян-Өндөр	52	608			608	600			
8	Баянцагаан	196	3050			3,050	3000			
9	Богд	392	8588			8,588	8600			
10	Бөмбөгөр	295	6010			6,010	6000			
11	Бууцагаан	587	10675			10,675	10600			
12	Галуут	725	35867			35,867	35900			
13	Гурванбулаг	494	9445			9,445	9400			
14	Жаргалант	559	23794			23,794	23800			
15	Жинст	179	4204			4,204	4200			
16	Заг	213	5497			5,497	5500			
17	Өлзийт	375	13730			13,730	13700			
18	Хүрээмарал	320	7638			7,638	7700			
19	Шинэжинст	34	300			300	300			
20	Эрдэнэцогт	884	55000			55,000	55000			
Нийт		6389	226650		30	226,680	226500			